

ЗАМЫН ЦАГДААГИЙН АЛБАНЫ 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН



Удирдлага, зохион байгуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Замын цагдаагийн алба нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр, бодлого чиглэлийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаандаа Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, түүгээр батлагдсан журам, заавруудыг мөрдлөг болгон, Цагдаагийн байгууллагаас 2017 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.

Тус алба нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Б/544-р тушаалаар Замын цагдаагийн алба болон зохион байгуулагдаж, 2017 оны 03 сарын 15-ны өдрийн А/13 дугаар тушаал, 2017 оны 06 сарын 30-ны өдрийн А/133 дугаар тушаалуудаар тус албаны бүтэц өөрчлөгдөн батлагдаж, одоо 2 газар, 14 хэлтэс, 1 тасагтай, албаны бүтцийн нэгжийн 572 алба хаагчтай, үүнээс офицер 293, ахлагч 262, энгийн 17 ажилтантай, харьяа нэгжийн буюу орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн Замын цагдаагийн тасаг, хэсэгт нийт 394 алба хаагчтай, үүнээс офицер 159, ахлагч 235, Төмөр зам, Иргэний нисэх, Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг дэх замын цагдаагийн нэгжид 26 үүнээс офицер 12, ахлагч 13, энгийн ажилтан 1 буюу улсын хэмжээнд нийт 992 алба хаагчтай, үүнээс офицер 464, ахлагч 510, энгийн 18 ажилтантай үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагаас 2017 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан албаны үйл ажиллагааны төлөвлөгөөг харьяа нэгжүүдээс ирүүлсэн саналуудыг тусган 5 бүлэгт ангилан нэгжийн стратеги зорилтыг хэрэгжүүлэхээр нийт 51 заалттайгаар баталж биелэлт, үр дүнг тооцон ажиллалаа.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 03 сарын 27-ны өдрийн А/36 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагаас 2017 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт”-ын дагуу тус албанд холбогдох нийт 25 баримт бичгүүдийн биелэлтийг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Цагдаагийн ерөнхий газрын холбогдох нэгжид тогтоосон хугацаанд хүргүүлэн үйл ажиллагаагаа тайлагнан ажилласан.

Улсын хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, төв, орон нутгийн хэмжээнд зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, ажлыг эрчимжүүлэх, нэгжийн удирдах алба хаагчдын эрх зүйн мэдлэг, ажил, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор Замын цагдаагийн албаны төв, орон нутгийн нэгжүүдийн ахлах зохицуулагч нарын сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 18-наас 20-ны өдрүүдэд, дарга нарын сургалт зөвлөгөөнийг 09 сарын 04-нөөс 08-ны өдрүүдэд зохион байгуулсан.

НҮБ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан тусгай төлөөлөгч ноён Жиан Тодд Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар манай улсад айлчилж байгаатай холбогдуулан тус албан дээр урьж, Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөл байдал, тулгарч байгаа бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай байгаа ажил, арга хэмжээнүүдийн талаар танилцуулсан.

Япон улсын “Жайка”-ийн Япон Улс болон Монгол Улс дахь суурин төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж, манай улсын замын хөдөлгөөний өнөөгийн нөхцөл байдал, Замын цагдаагийн албаны үйл ажиллагаатай танилцуулан туршлага судалж, мэдээлэл солилцсон.

Зам, тээврийн хөгжлийн сайдын урилгаар манай улсад айлчилсан Азийн хөгжлийн банкны Зүүн Азийн Тээвэр, холбооны салбарын тээврийн ахлах мэргэжилтэн Ки-Жүн Кимийг хүлээн авч уулзаж, нөхцөл байдлаа танилцуулсан. Тус байгууллага нь манай улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр 1 сая долларын буцалтгүй тусламжийн төслийг хэрэгжүүлж байна.

Олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу 2018 онд 27 байнгын хяналтын цэг байгуулахад шаардагдах 2,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт суулгах ажлыг зохион байгуулж, тус хяналтын цэгүүдэд шаардагдах техник, хэрэгслийн зардал болох 563,2 сая төгрөгийн санхүүжилтийг Зам тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төвтэй хамтран шийдвэрлүүлсэн.

Нийслэлийн төсөв хөрөнгө, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн дэмжлэгээр 107,9 сая төгрөгийн санхүүжилтээр 60 ширхэг тандагч багаж, 60 ширхэг цагдаагийн шалгах багаж, 499,2 сая төгрөгийн санхүүжилтээр хөдөлгөөнт эргүүлийн 3 автомашин болон бусад шаардлагатай тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл, ажил арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлүүлж ажилласан.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

2017 оны эхний 11 сарын байдлаар улсын хэмжээнд зам тээврийн гэмт хэрэг 1583 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 114 нэгжээр буюу -6,7 хувиар, гэмтсэн хүний тоо 1104 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 74 нэгжээр буюу -6,3 хувиар тус тус буурч, нас барсан хүний тоо 383 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14 нэгжээр буюу 3,8 хувиар өссөн дүнтэй байна.

Зам тээврийн ослын улмаас нас барсан хүний тоог хэрэг гарсан байршлаар нь судалж үзвэл 77 буюу 20,1% нийслэлд, 306 буюу 79,9% орон нутагт бүртгэгдсэн байна.

Тайлангийн хугацаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 2002 гомдол, мэдээлэл хүлээн авч, нийт 2014 гомдол мэдээлэл шалгаснаас 661 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 1326 гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлж, 5 гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, нийт 1992 гомдол мэдээллийг шалган шийдвэрлэж ажилласан.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад учирсан 26,328,910,82 төгрөгийн хохирлоос 28,774,946,01 төгрөг буюу 100 хувийг нөхөн төлүүлсэн, хохирол нөхөн төлүүлэх зорилгоор 10,933,438,13 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилж ажилласан.

2017 оны эхний 11 сарын байдлаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослын нийт 106,438 дуудлага мэдээллийг хүлээн авч бүртгэн хэргийн газрын үзлэгийн баг, дүүргүүдийн бүсийн зохицуулагч нарт дамжуулан хэргийн газарт шуурхай очиж байгаа байдалд хяналт тавин ажилласан.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож гудамж замын хөдөлгөөнд оролцсон 14364, хөдөлгөөнд оролцох шаардлага хангаагүй 1660 журамлагдсан тээврийн хэрэгсэл, Цагдаагийн ерөнхий газрын эрэн сурвалжлах АСАП санд бүртгэлтэй, эрэн сурвалжлагдаж байсан 358 хүнийг саатуулж, цагдаагийн нийтлэг үүргийн дагуу илрүүлсэн 993 зөрчлийг бүртгэн харьяаллын дагуу холбогдох албадад шилжүүлсэн.

Хамгаалалт, зохицуулалтын талаар:

Тайлангийн хугацаанд тус алба бүх нийтийг хамарсан баяр ёслол, олон нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалт зохицуулалтын үйл ажиллагааг хууль тогтоомж, хуваарь төлөвлөгөөний дагуу зөрчил дутагдалгүй үүрэг гүйцэтгэсэн. Тухайлбал,

- Шинэ жилийн баяр наадам
 - Цагаан сар
 - Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр
 - “Улаанбаатар марафон 2017” олон улсын гүйлтийн тэмцээн
 - Автомашингүй өдөр
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн болон дахин санал хураалтын үеийн хамгаалалт зохицуулалтын үйл ажиллагаа
 - Их Монгол улс байгуулагдсаны ой, Үндэсний их баяр наадмын хамгаалалт, зохицуулалтын үйл ажиллагаа
 - “Төрийн далбаанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ”,
 - “Дээлтэй Монгол”,
 - “Улаанбаатарын үдэш” цэнгүүн
 - Хүрээ-цам Даншиг наадам 2017 шашин урлагийн баяр цэнгүүн
 - Хичээлийн шинэ жилийн нээлт
 - Эзэн Богд Чингис хааны мэндэлсний 855 жил, “Монгол бахархлын өдөр”
 - Бүгд найрамдах улс тунхагласны 93 жилийн ойн баярын үеийн зэрэг томоохон арга хэмжээний үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт, зохицуулалтын үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэдээ тайлан танилцуулгыг тухай бүр Цагдаагийн ерөнхий газарт илтгэн танилцуулж ажилласан.
- Мөн олон нийтийг хамарсан жагсаал цуглаан, гадаадын зочид төлөөлөгчдийн зорчих үеийн зэрэг давхардсан тоогоор 64 удаагийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт, зохицуулалтын ажиллагааг ямар нэгэн зөрчил дутагдалгүй удирдан зохион байгуулж явуулсан.

Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах чиглэлээр:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх ажлын хүрээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх өдөр”, “Автомашингүй өдөр арга хэмжээ”, “Нээлттэй хаалганы өдөр”, “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Ногоон гэрэл цагаан шугам”, “Зам тээврийн ослоор хохирогсдыг хүндэтгэх өдөр” ажил, арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Тайлангийн хугацаанд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомж, дүрэм, стандартыг олон нийтэд сурталчлан таниулах, цагдаагийн байгууллага, Замын цагдаагийн албанаас явуулж байгаа бодлого, чиглэлийг олон нийтэд хүргэх, зорилгоор 52 удаагийн уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэг, ажил, арга хэмжээ зохион байгуулж хамтран ажиллаж байна.

Телевизийн нэвтрүүлэг 569 удаа, радиогийн нэвтрүүлэг 198 удаа орж, сэрэмжлүүлэг мэдээ мэдээлэл өгсөн. Өдөр тутмын болон бусад сонин, хэвлэлд давхардсан тоогоор 1117 ярилцлага өгч, 26 интернет, вэб сайтад 638 нийтлэл, мэдээ сэрэмжлүүлэг тус тус хүргэж ажилласан.

Нэгдсэн үндэстний байгууллагатай хамтран зохион байгуулсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах “Хурдаа хасаж- Амь насаа аваръя” 7 хоногийн хүрээнд Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг Зорчигч тээврийн нэгтгэл зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудын 500 гаруй жолооч, техникийн ажилтнуудад “Хурд ба хөдөлгөөний аюулгүй байдал” сэдвээр, Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн жолооч, ажилтан 48 хүнд, ерөнхий боловсролын сургуулиудын 1086 хүүхэд, 186 багш, сурган хүмүүжүүлэгчдэд, 21 сэтгүүлчдэд сургалт орж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг хийсэн.

Хурд хэтрүүлэхээс сэргийлсэн шторк, хурд хэтрүүлэх аюул, хор уршгийн талаар 2 төрлийн инфографикийг хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан.

Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран Зам тээврийн осол, хэргийг бууруулах зорилгоор 6, хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх утга бүхий 9 төрлийн шторк бэлтгэн 23 телевизээр иргэд, олон нийтэд тогтмол, хотын хэмжээнд байрлах зар сурталчилгааны 42, орон сууцны лифт доторх сурталчилгааны 62, арилжааны 12 банкнуудын

LED дэлгэц болон кинотеатруудын дэлгэцээр гаргаж иргэд олон нийтэд сэрэмжлүүлэг болгон урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор “Гар утас”, “Хурд”, “Согтуу”, “Мотоцикл”, “Хүүхэд”, “Хамгаалах суудал” сэдвээр 6 төрлийн сэрэмжлүүлэг шторк бэлтгэн 23 телевиз, 15 FM, радиогоор иргэд, олон нийтэд хүргэсэн.

Хүүхдийг замын хөдөлгөөнд аюулгүй оролцох мэдлэг олгох чиглэлээр 4 төрлийн дуун зөвлөмж, “Зогсоод, хараад, сонсоод гарцаар гараарай” дууг зохиолгож анимейшн хэлбэрээр клипжүүлэн цахим хуудсуудаар түгээж, 10 төрлийн аудио шторк бүтээж 15 радио FM-үүдээр цацуулсан.

“Eagle” телевизтэй хамтран “Сэргийлэгч” зорилтот нэвтрүүлэг, ТВ-9 телевизийн “Гарц” нэвтрүүлгийн 3 дугаар, ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвөөс бэлтгэн гаргадаг “Амрыг эрье” нэвтрүүлгийг бэлтгэн гаргаж, шууд нэвтрүүлэгт давхардсан тоогоор 11 удаа орж /“Эко” телевизийн “Замын цагдаа сонсож байна”, “Малчин” телевизийн “Иргэний боловсролд”, “MN-25” телевизийн “Авто-25” шууд нэвтрүүлгүүд, “Монгол HD” телевизийн “Өнөө өглөө”, “NTV”, “ETV”, “MNC” телевизүүдийн “Зочны цаг”, “UBS” телевизийн “Тодруулга” нэвтрүүлгүүдэд/ мэдээ мэдээлэл өгсөн. Давхардсан тоогоор 55 удаа мэдээ, сэрэмжлүүлэг өгч /үүнээс Үндэсний баяр наадмын өдрүүдэд 18 телевизэд/ иргэд олон нийтэд 2-3 удаагийн давтамжтайгаар хүргүүлсэн.

“Замын цагдаагийн алба” цахим хуудсаар зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой, соёлтой оролцохыг уриалж 151 мэдээ, мэдээлэл, 8 төрлийн нэвтрүүлэг, 15 видео сэрэмжлүүлгийг байршуулан, хамтран ажилладаг бусад 26 сайт, 4 сонинд тогтмол мэдээ, мэдээлэл өгч ажилласан бөгөөд өдөр тутмын болон бусад сонин, хэвлэлд давхардсан тоогоор 129 удаа нийтлэл, мэдээлэл, сэрэмжлүүлэг хэвлүүлж ажилласан.

Хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох үеийнх нь аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр мэдлэг мэдээлэл олгох, хөдөлгөөнд оролцох үеийнх нь аюулгүй байдлын дадлыг зөв олгох, замын хөдөлгөөний хууль дүрмийг сурталчлах зорилгоор цэцэрлэгийн багачууд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд уламжлал болгон 36 дахь жилдээ “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Ногоон гэрэл-цагаан шугам” тэмцээнүүдийг улсын хэмжээнд 2 үе шаттайгаар амжилттай зохион байгуулсан.

Энэ жилийн тэмцээнд оролцогч баг бүрээр хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, мэдлэг олгох богино хэмжээний видео шторк бэлтгүүлж, олон нийтэд сурталчилж байснаараа шинэлэг, онцлог ажил болсон.

Техник, замын хяналтын чиглэлээр:

Замын цагдаагийн албаны даргын баталсан 2017 онд тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавих, зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор хяналт, шалгалтын календарчилсан хуваарь, төлөвлөгөөий дагуу “Эвдрэл гэмтэл, техникийн байдал”, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тээврийн хэрэгслийн өнгө үзэмжинд тавих хяналт”, “Ачааны автомашин, ачаа тээвэрлэлт” арга хэмжээг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/62 дугаар тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”, “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавих ба хэрэглэх. Ерөнхий шаардлага” MNS 4979:2000 стандартын хэрэгжилтийг хангуулах, Замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, тусгай дуут болон гэрэл дохиог зохих зөвшөөрөлгүйгээр ашиглаж байгаа зөрчлийг арилгах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвтэй хамтран “Эрчимжүүлэлт” арга хэмжээг 2017.08.21-2017.09.10-ны өдрүүдэд зохион явуулсан.

Арга хэмжээний хүрээнд алба хаагчдын дунд 16, аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсдын дунд 59 удаагийн сургалтыг зохион байгуулж, арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг 25 телевиз, 9 сонин, сэтгүүл, 10 FM радиод өгч ажилласан. Гудамж замын хяналт шалгалтын хүрээнд тусгай дуут болон гэрэл дохионы зөрчилтэй хөдөлгөөнд оролцож явсан нийт 78 тээврийн хэрэгслийг илрүүлэн, 10 тээврийн хэрэгслийн тусгай дуут болон гэрэл дохионы хэрэгслийг хурааж, бичиг баримтын хамт Бүртгэл хяналтын төвд шилжүүлэн, 66 жолоочид Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 14.7.16 дахь хэсэгт заасны дагуу 6600000 төгрөгийн торгууль оногдуулсан.

Түүнчлэн дээрх “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журам”-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/292 дугаар тушаалаар шинэчлэн баталж, журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Замын цагдаагийн албаны ахлах мэргэжилтнүүд, орон нутаг дахь Замын цагдаагийн тасгийн дарга, Зам тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Замын ашиглалт засварын хэлтсийн мэргэжилтнүүд, “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын бүс нутаг хариуцсан хяналтын инженерүүд, тухайн чиглэлүүдийн зам хариуцагч компаниудын инженер, техникийн ажилтнууд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын байцаагч нар хамтран 15 аймгийн хатуу хучилттай замуудын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэлд үзлэг шалгалтыг 2017 оны 04 дүгээр сарын 15-наас 30-ны хооронд зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын орлогчоор ахлуулсан “Замын ачааллыг бууруулах ажлын хэсгийн хурал”-д Чингисийн өргөн чөлөө, Зайсангийн гудамжны хөдөлгөөн зохион байгуулалтыг өөрчлөх, Зайсангийн гудамж, “Оргил” худалдааны төвийн зүүн хойд талын уулзварт түр гэрлэн дохио тавих, Богд хааны музейн урд замыг зүүнээс баруун тийш нэг чигийн хөдөлгөөнд оруулах зэрэг ажлуудыг танилцуулснаар Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо “Авто плаза” төвийн арын уулзвар, Сүхбаатар дүүргийн 5 дугаар хороо “Өгөөж чихэр боов” ХХК-ний баруун урд уулзвар, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Хөдөө аж ахуйн их сургуулийн зүүн хойд уулзвар, Хан-Уул дүүргийн 15 дугаар хороо “Богд Жавзандамба хутагт”-ын гудамж, “Оргил” худалдааны төвийн зүүн уулзваруудад өргөтгөл шинэчлэлтийн ажил хийлгэж, уулзварын нэвтрүүлэх чадварыг сайжруулсан.

Орон нутгийн хяналтын чиглэлээр:

Зам, тээврийн хөгжлийн яаманд орон нутгийн замын хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, тулгарч байгаа бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай байгаа ажил, арга хэмжээнүүдийн талаар танилцуулсны дүнд дараах шийдвэрүүдийг гаргаж хэрэгжүүлэхээр болсон. Үүнд:

-Улаанбаатар-Дарханы чиглэлийн авто замыг олон улсын чанартай 1-р зэргийн эсрэг хөдөлгөөнтэй, тусгаарлах зурвастай, дөрвөн эгнээтэй цемент-бетонон хучилттай болгох

-Хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл /тэмдэг заалт, хэвтээ тэмдэглэл, хайс хашилт, нэмэлт тоноглол/-оор иж бүрэн тохижуулж, олон улсын чанартай жишиг зам болгох

-Орон нутгийн замд хяналт, шалгалтын ажилд зориулан 30 ширхэг хурд хэмжигчээр хангах Тухайн чиглэлийн авто замд байнгын иж бүрэн хяналтын цэг /пост/-байгуулах шийдвэрүүдийг гаргасан.

“Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” аян хэрэгжүүлсэн талаар:

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2017 оныг “Иргэдэд ойр, эрх зүйн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан орон нутгийн автозамд гарч буй осол хэргийг бууруулах, иргэдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хүртээмжийг сайжруулах, урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор Замын цагдаагийн албанаас Хууль зүй дотоод хэргийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газартай хамтран орон нутгийн автозамд үйлдэгдэж байгаа зам, тээврийн гэмт хэрэг, ослыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор иргэдийн зорчих, шилжилт хөдөлгөөн нэмэгддэг үетэй уялдуулан 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 16-ны өдөр хүртэлх 4 сарын хугацаанд “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” аяныг зохион байгуулж дүгнэсэн.

Дээрх аяны хүрээнд орон нутагт гарч буй зам тээврийн гэмт хэрэг, ослыг бууруулахад чиглэсэн ажил, арга хэмжээг орон нутаг дахь цагдаагийн газар хэлтсийн хүн, хүч, техник хэрэгслийг дайчлан зохион байгуулж, тасралтгүй ажилласны үр дүнд аяны хугацаанд зам тээврийн гэмт хэрэг 1.9 хувиар, хүний амь нас хохирсон тохиолдол 12.4 хувиар, гэмтсэн хүн 2.3 хувиар тус тус буурсан үр дүн гарсан байна.

Орон нутгийн зам дахь осол хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/170 дугаар тушаалаар орон нутгийн хэмжээнд “Цагдаагийн хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагааг дээшлүүлэн, алба хаагчдын ажиллах арга, хэлбэрийг өөрчилж, ажлын үр дүнг тооцох чиглэлээр судалж, санал дүгнэлт гарган, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулагдан ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд ЦЕГ-ын Мэдээлэл, холбоо, технологийн төвөөс уг постуудад байгаа телекамерын техникийн хүчин чадалд үзлэг, шалгалт, холбогдох засвар үйлчилгээ хийн Архангай аймгийн Хашаат сумын нутаг дахь Тарнын гүүрний пост, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг дэвсгэрт байрлах пост, Төв аймгийн Лүн сум дахь пост, Нийслэлийн Багахангай дүүрэг дэх пост, Багануур дүүргийн Хэрлэнгийн гүүрэнд ажиллаж байгаа түр пост зэрэг 5 постоос бусад 8 постыг ЦЕГ-ын Шуурхай удирдлагын штабтай холбож, хяналт тавин ажиллаж байна.

“Оюутан тээвэр”-2 нэгдсэн арга хэмжээг орон нутгийн хэмжээнд 08 сарын 18-09 сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын замын цагдаагийн тасаг, хэсгээс нэгдсэн арга хэмжээний хүрээнд 63.978 тээврийн хэрэгсэл шалгаж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 717 зөрчил илрүүлж, цагдаагийн нийтлэг үүргийн хүрээнд хууль бус ангын мах тээвэрлэсэн 1, хуш модны самар хууль бусаар бэлтгэж, нэг тонн самар тээвэрлэсэн 1 зөрчил, хууль бусаар эдлэг шонхор агнан, тээвэрлэж явсан 2 тээврийн хэрэгсэл илрүүлж, тээвэрлэж явсан 5 идлэг шонхрын хамт орон нутгийн мэргэжлийн хяналтын газар, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Эрүү, Мөрдөн байцаах тасгуудад шилжүүлэн өгч ажилласан байна.

Албаны даргын 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/27 тоот тушаалаар батлагдсан Замын хөдөлгөөний зохицуулалт, хяналт зохион байгуулах албаны “Ерөнхий төлөвлөгөө”-ний хүрээнд улсын хэмжээнд “Мотоциклын хөдөлгөөн” нэгдсэн арга хэмжээг нийслэлийн алслагдсан 3 дүүрэг, 21 аймгийн нутаг дэвсгэрт 2017 оны 05 сарын 25-наас 08 сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулж арга хэмжээний хүрээнд 296 мотоциклд улсын дугаар олгуулж, 1236 иргэнийг “А” ангиллын жолооны сургалтад хамруулж, хамгаалах малгайгүй хөдөлгөөнд оролцсон 620 жолоочийн зөрчлийг арилгуулж шийдвэрлэсэн байна.

Албаны сургалт, соён гэгээрүүлэх ажлын талаар:

“Сургалтын календарчилсан төлөвлөгөө, хөтөлбөр батлах тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны Б/58 дугаар тушаал, 6 заалт бүхий үүрэг, ажлын чиглэл ирүүлсний дагуу тус албаны 2017 оны сургалтын календарчилсан төлөвлөгөөг сургалтын сэдэв, давтамж, цаг хугацааны хамт батлуулан харьяа газар хэлтсүүдэд хүргүүлж, биелэлт үр дүнг хагас жил, бүтэн жилээр нэгтгэн цагдаагийн ерөнхий газрын хүний нөөц сургалтын хэлтэст хүргүүлсэн.

Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх арга зүйг боловсронгуй болгох, байгууллагын үйл ажиллагаа болон алба хаагчдын харилцааг хөгжүүлэх зорилгоор “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр албаны хэмжээнд нийт 22 ажил, арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлснээр жилийн эцсийн байдлаар 91 хувийн гүйцэтгэлтэйгээр биелэлт үр дүнг тооцон Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Албаны хэмжээнд нийт 10 төрлийн тэмцээнийг зохион байгуулан нийлбэр дүнгээр “Чадварлаг хамт олон” цогцолбор тэмцээнд тэргүүн байрыг Баянгол дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэс, хоёрдугаар байрыг Сонгинохайрхан дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэс эзэлж тус бүр 20 алба хаагч гэр бүлийн хамт гадаад улсад аялж амрах эрхийн бичгээр шагнагдсаны дагуу Баянгол дүүрэг дэх замын цагдаагийн хэлтсийн алба хаагчид БНХАУ-ын Манжуур хот, Сонгинохайрхан дүүрэг дэх замын цагдаагийн хэлтсийн алба хаагчид ОХУ-ын Эрхүү хотод 5 хоногийн аялал хийсэн.

Тус тэмцээнд гуравдугаар байр эзэлсэн Хан-уул дүүрэг дэх замын цагдаагийн хэлтсийн 15 алба хаагч гэр бүлийн хамт Дорноговь аймгийн байгалийн дурсгалт газруудаар 3 хоногийн аялал хийсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны Б/58 тоот тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2017 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 2017 оны 10 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд “Шилдэг зохицуулагч-2017” тэмцээнийг албаны хэмжээнд зохион байгуулан дүгнэсэн.

Нэгдсэн дүнгээр тэргүүн байрыг Чингэлтэй дүүрэг дэх замын цагдаагийн хэлтсийн баг, 2-р байрыг Баянзүрх дүүрэг дэх замын цагдаагийн хэлтэс, 3-р байрыг Баянгол дүүрэг дэх замын цагдаагийн хэлтэс эзэлсэн.

Тэмцээний дүнгээр орон нутгийн нэгжүүдийн хэмжээнд тэргүүн байрыг Өмнөговь, дэд байрыг Хэнтий, гуравдугаар байрт Дорнод, тусгай байрт Өвөрхангай аймаг дахь замын цагдаагийн тасгийн багууд шалгарсан.

Улсын хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын нэгдмэл байдал, уялдаа холбоог сайжруулах, хуулийн хэрэгжилтийг жигд хангуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах үүрэг бүхий зохицуулагч, цагдаа зохицуулагч нарт төв, орон нутгийн замын хөдөлгөөний нөхцөл байдлын онцлогийг танин мэдүүлэх, тэдгээр нөхцөлд дасан зохицох, хөрвөн ажиллах, ажил мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, зорилгоор алба хаагчдыг 10 хоногийн хугацаагаар сэлгэн ажиллуулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан 2017 оны 05

сарын 01-ний өдрөөс 2017 оны 06 сарын 09-ний хооронд хэрэгжүүлж, нийслэлийн 9 дүүрэг, орон нутгийн 21 аймгийн замын цагдаагийн нэгжийн 96 алба хаагчийг оролцуулсан.

Түүнчлэн алба хаагчдын гар утсанд LAWSMN аппликейшн суулгаж, цахим хэлбэрээр шинээр гарсан хууль тогтоомжийг цаг тухайд нь судлуулж, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэн ажиллаж байна.

Албаны сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу “Сонгуулийн хуулийн хэрэгжилтийг хангахад цагдаагийн байгууллагаас анхаарах зүйл”, “Фото зургийн зөрчлийн талаарх сургалт”, “Ачааны автомашины стандарт”, “Хүн тээвэрлэх автомашины стандарт”, “Замын хөдөлгөөний дүрэм”, “Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам”, “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”, “Осол, зөрчлийг санд шивэх”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”, “Цагдаагийн албаны тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Төрийн болон албаны нууцын тухай хууль”, “Монгол улсын хилийн тухай хууль”, “Дотоодын цэргийн тухай хууль”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2017 оны А/97, А/42 тушаалаар баталсан “Галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх журам”, ЦЕГ-ын даргын 2017 оны 04-дүгээр сарын 19-ны өдрийн А/54 “Хэт богино долгионы радио холбоонд ашиглах торны нэр, дуудлага, удирдлагаас өгөх команд, харилцах кодыг шинэчлэн батлах тухай” тушаал, зөвлөмж, “Цагдаагийн байгууллагын хэмжээнд баримт бичиг, биет зүйлийг хамгаалах, албан бичиг боловсруулахад мөрдөх аргачлал” зэрэг сэдвүүдээр 120 удаагийн 60 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Албаны гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага судлах, суралцах, ажлын хүрээнд 2017 онд тус албанаас гадаад орнуудад болсон дараах сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт алба хаагчдаа хамруулсан. Үүнд:

Малайз Улсын Куала Лампур хотноо 2017 оны 03 дугаар сарын 18-наас 14 хоногийн хугацаатай зохион байгуулагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сэдэвт сургалтад 1 алба хаагч,

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын өөртөө засах орны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимээс зохион байгуулж буй “Монгол улсын цагдаагийн байгууллагын дунд түвшний удирдах болон ахлах албан тушаалтнуудад зориулсан” 7 хоногийн сургалтад 1 алба хаагч,

Монголын нутгийн удирдлагын нийгэмлэгтэй хамтран Япон улсын Шизока мужийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын туршлага судлах 5 хоногийн сургалтад 2 алба хаагч,

Бүгд найрамдах Филиппин улсад 2017 оны 5 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд НҮБ-аас зохион явуулсан “Хүүхэд өртөж буй зам тээврийн осол, гэмтлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн хурал”-д тус албанаас 1 алба хаагч,

Бүгд найрамдах Солонгос улсад 2017 оны 12 дугаар сарын 11-нээс 16-ны өдрүүдэд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын туршлага судлах сургалтад 1 алба хаагч,

Бүгд найрамдах Турк улсад 2017 оны 09 сарын 16-наас 23-ны өдрүүдэд зохион явагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт сургалтад 1 алба хаагч

Оросын холбооны улсын Буриад улсын Улан-Удэ хотод 2017 оны 10 дугаар сарын 23-наас 25-ны өдрүүдэд зохион явагдсан ОХУ-ын Дотоод явдлын яам, Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хамтран зохион байгуулсан “Хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөлдөх уулзалтад ХЗДХЯамны ажлын хэсэгт тус албанаас нэг алба хаагч,

Бүгд найрамдах Турк улсад 2017 оны 11 сарын 28-наас 30-ны өдрүүдэд зохион явагдсан “Олон улсын аж үйлдвэрлэлт, хот байгуулалтын үзэсгэлэн”-д 1 алба хаагч оролцож, дээрх гадаад орнуудад зохион явагдсан сургалт, зөвлөгөөнүүдээс өөрийн оронд тусган хэрэгжүүлэх боломжтой ажлын талаарх санал бэлтгэн цагдаагийн төв байгууллага, албаны удирдлагад танилцуулж, алба хаагчдыг мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсан.

Байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, алба хаагчийн ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

Албаны үйл ажиллагаа, алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран тус албанд хэрэгцээ шаардлагатай байсан бэлэн бусаар торгох **CROSSCALL TRAKKER-M1 CORE** шалгах төхөөрөмж 60 ширхгийг нэмж авч, харьяа газар хэлтсүүдэд хуваарилан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Бэлэн бус торгуулийн системийн сүлжээний ачааллыг багасгах, сүлжээ тасрах, удаашрах байдлаас сэргийлж Скайтел компаниас гадна Жи-мобайл компанитай гэрээ байгуулан 100 ширхэг дата дугаарыг авч 2017 оны 05 сараас эхлэн ашиглаж байна.

Шинэчлэн батлагдсан Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын өөрчлөлттэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн нэгдсэн санд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл технологи, холбооны төвд уламжлан өөрчлөлт шинэчлэлтийг оруулсан. Үүнтэй холбоотойгоор Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд ажиллах заавар, гарын авлага гарган алба хаагчдыг мэдээллээр хангаж ажилласан. Мөн дээрх шинэчлэлийг цагдаагийн шалгах төхөөрөмжид оруулж, зарим зөрчилд “сануулга” өгөх өөрчлөлтийг шинээр оруулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Бэлэн бус торгуультай холбоотой асуудлаар тус албанд хандсан 11153 иргэний гомдол, хүсэлтийг хүлээн авч зохих заавар журмын дагуу шийдвэрлэсэн.

Хамгаалалт, зохицуулалтад ажиллах үед радио станцын ярианы тархалт, алслалтыг сайжруулахаар дахин дамжуулах 2 ширхэг станц авч угсралт суурилуулалтын ажлыг хийж гүйцэтгэн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж эхлээд байна. Мөн хэт богино долгионы радио станцын 300 ширхэг зай авч алба хаагчдад тараан олгосон.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан үндсэн чиглэлд заасны дагуу олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу байнгын хяналтын 27 пост байгуулахаар төлөвлөж, шаардагдах 2,1 тэрбум төгрөг, бэлэн бус торгуулийн системийг улсын хэмжээнд нэгтгэн үйл ажиллагааг сайжруулахад шаардагдах 5,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох тооцоо, судалгаа, хяналтын цэгийн байршлын саналыг Цагдаагийн ерөнхий газраар уламжлуулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.

Мөн дээрх хяналтын цэгүүдэд шаардагдах техник, хэрэгслийн зардал болох 563,2 сая төгрөгийн санхүүжилтийг Зам, тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төвтэй хамтран шийдвэрлүүлээд байна.

ЦЕГ-ын даргын шийдвэрээр орон нутгийн замд хяналт тавин ажиллаж байгаа цагдаагийн 13 постын үйл ажиллагааг эрчимжүүлж, бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэн эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, замын цагдаагийн зохицуулагч, цагдаа зохицуулагч нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд уг постуудын үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор тус албаны Орон нутгийн хяналтын хэлтсийн алба хаагчид ЦЕГ-ын Шуурхай удирдлагын штабын бүрэлдэхүүнд томилогдон 24 цагийн хяналт тавин ажиллаж, хоногийн нөхцөл байдал, ажлын үр дүн, шийдвэрлүүлэх саналыг ЦЕГ-ын Тэргүүн дэд дарга, албаны дарга нарт танилцуулан ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас Азийн хөгжлийн банктэй хамтран зохион байгуулж байгаа “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах” төслийн хүрээнд тус банкны буцалтгүй тусламжаар зам тээврийн ослын газарт цахим хэлбэрээр үзлэг хийж бүртгэлжүүлэх, статистик судалгаа, тайланг богино хугацаанд боловсруулах боломж бүхий программ хангамжийг боловсруулж байна. Тус төслийн хүрээнд Замын цагдаагийн албаны харьяа нэгжийн алба хаагчдад 100 орчим ширхэг таблет багаж, мэдээлэл нэгтгэн боловсруулах сервер зэрэг тоног төхөөрөмж олгох ба зам тээврийн ослын газар дээр зураг авах, зураглал үйлдэх, бүртгэх үйлдлийг гүйцэтгэх боломж бүрдэх юм.

Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн нутагт баригдсан 1м кв нь 1,700,000 төгрөгийн үнэ бүхий Шинэ өргөө хорооллын орон сууцыг 20-30 хувийн урьдчилгаа төлбөр бүхий банкны 8 хувийн хөнгөлөлттэй зээлээр худалдан авах захиалгад тус албанаас 30 алба хаагчийг хамруулахаар материалыг хүргүүлсэн.

Тус албаны Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-уул дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсийн гэр бүлийн зориулалтаар газар өмчлөөгүй алба хаагчдын судалгааг гаргаж, тус бүр 20 алба хаагчид газар эзэмших, өмчлөх эрх олгуулах ажлыг харьяа дүүргийн Засаг даргад танилцуулан газар олгох ажлыг шийдвэрлүүлсэн.

Улаанбаатар хотын агаарын бохирдол, утаанаас алба хаагчдыг хамгаалах, ханиад томуунаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2100 ширхэг маск авснаас 1580 ширхэг амны хаалтыг харьяа нэгжүүдэд хувиарлан алба хаагчдад олгон ашиглаж байна.

Хүйтний улиралтай холбогдуулан албаны цайны газарт халуун аарц бэлтгэж, гудамж замд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад өглөө өдөр 2 ээлжээр өгч байна.

Мөн алба хаагчдыг үүрэг гүйцэтгэхийн өмнө болон ажлаас буух үед хүчилтөрөгчийн коктейль уулгах ажлыг төв конторт болон дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсүүдэд зохион байгуулан бүх алба хаагчдыг хамруулж байна.

Алба хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 163 алба хаагчдад тус бүр 1.5 тонн, нийт 240 тн нүүрсийг хөнгөлөлттэй үнээр тарааж, Төв аймгийн Батсүмбэр суманд байрлах 8 га газар алба хаагчдын хүнсний хэрэгцээг хангах зорилгоор төмс хүнсний ногоо тариалж, алба хаагч бүрд нэг шуудай төмсийг хөнгөлөлттэй үнээр тараан олгосон.

Цагдаагийн ерөнхий газар, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагаас зохион байгуулж байгаа “Гэрээр бэлэг барья” төсөлд тус албанаас 1 алба хаагчийг хамруулж, гэр олгуулсан. Мөн I and R Mongolia ХХК, БНСУ-ын “Paldo” компани хамтран хэрэгжүүлсэн “Дулаан гэр–Сайхан сэтгэл” сайн үйлсийн аяны хүрээнд тус албаны 5 алба хаагчдад 5 ханатай иж бүрэн гэр болон зуух яндан, хүнсний зүйлс олгох ажлыг зохион байгуулсан.

Нийгмийн хариуцлагыг дээдлэгч Мобиком корпораци болон Дэлхийн шилдэг гар утас үйлдвэрлэгчдийн нэг “Huawei” компанийн Монгол дахь албан ёсны төлөөлөгчийн газраас албаны шуурхай байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор тус албаны 50 алба хаагчдад “Huawei Y3” маркийн ухаалаг гар утсыг бэлэглэсэн.

Нийслэлийн дүүргүүд дэх замын цагдаагийн хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нар хариуцсан алба хаагчдынхаа ар гэрээр орж тэдний гэр бүлийнхэнтэй уулзаж, ахуй амьдралын талаарх судалгааг авч, 18 алба хаагчийн ар гэр, ахуй амьдралд тус нэмэр болохоор тодорхой ажил арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлсэн. Мөн харьяа газар, хэлтэс бүр алба хаагчдын гэр бүлийн төлөөлөлтэй хийх уулзалтыг зохион байгуулж, Цагдаагийн байгууллага, Замын цагдаагийн албанаас явуулж байгаа үйл ажиллагаа, бодлого чиглэлийг танилцуулан тэдний санал хүсэлтийг хүлээн авч ажилласан.

Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй хамтран алба хаагчдыг гудамж замд хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэж байх үед нь биеийн ерөнхий байдлыг тодорхойлох, цусны даралт, пульс хэмжих, захын судасны хүчилтөрөгчийн хэмжээг тодорхойлох шинжилгээнд шөнийн цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байсан 48 алба хаагчийг хамруулж, дүгнэлт гаргуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй хамтран 33 алба хаагчдын уушгины үйл ажиллагаанд тандалт судалгаа хийх ажлыг зохион байгуулсан.

Тус албаны 327 алба хаагчдад томуугийн эсрэг вакцин хийлгэж, 390 алба хаагчдыг Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж дүгнэлтийг гаргуулж ажилласан.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 112 дугаар тогтоол “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тус албаны 40-65 насны 149 алба хаагчийг “Тэгш саруул” эмнэлэгт элэгний В,С вирусийг илрүүлэх шинжилгээнд хамруулсан.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албатай хамтран тус албаны 40 дээш насны алба хаагчдыг 3 багц шинжилгээнд хамрагдах 31 лабораторийн судалгааг хүргүүлж, алба хаагчдыг шинжилгээнд бүрэн хамруулсан.

Цаашид тус албаны ажил, үйлчилгээг иргэд, олон нийтэд шуурхай хүртээмжтэй хүргэх, тэдний итгэл, дэмжлэгийг хүлээж, иргэд цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, ил тод, нээлттэй байх, албаны тогтвортой хөгжил, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд тодорхой ахиц дэвшил, мэдэгдэхүйц үр дүн гаргах зорилт тавин ажиллаж байна.

ТА БҮХНИЙ АЛТАН ШАР ЗАМ ТАНЬ ӨЛЗИЙТЭЙ БАЙГ



ЗАМЫН ЦАГДААГИЙН АЛБА